

Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 12-р сарын 31-ний өдрийн 01/180 тоот тушаалаар батлав.

Мэдээллийн нууцыг "Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн 22 дугаар зүйлийн 3 дугаар заалтын дагуу хадгална.

Улсын тайлан маягт АУ-7

ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 20... ОНЫ ЖИЛИЙН МЭДЭЭ

Хэсэг 1. Хаягийн хэсэг

Регистрийн дугаар						
Аж ахуйн нэгж, байгууллагын нэр						
Байршил	Нэр				Код	
Аймаг, нийслэл						
Сум, дүүрэг						
Үйл ажиллагааны салбарын чиглэл						

1. Аж ахуйн нэгж, байгууллага дараа оны 2-р сарын 18-ны дотор сумын ЗДТГ, дүүргийн статистикийн хэлтэст маягтаар, сумын ЗДТГ, дүүргийн статистикийн хэлтэс 2-р сарын 25-нд аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газарт маягтаар;
2. Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар нь 3-р сарын 4-нд Үндэсний статистикийн хороонд цахим шуудангаар дамжуулна.
3. Шууд мэдээлдэг яам, бусад газар 3-р сарын 4-ний дотор Үндэсний статистикийн хороонд маягтаар ирүүлнэ.

Хариуцлагын хэлбэр	код
Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	11
Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	12
Хоршоо	21
Хувьцаат компани	31
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	32
Төрийн өмчит үйлдвэрийн газар	40
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	50
Төрийн бус байгууллага	70
Бусад	80

Өмчийн хэлбэр		код	
Төрийн	өмчийн		11
	өмчийн оролцоотой %	12
	гадаадтай хамтарсан %	13
Орон нутгийн	өмчийн		31
	өмчийн оролцоотой %	32
	гадаадтай хамтарсан %	33
Хувийн	монгол улсын иргэний		21
	гадаадтай хамтарсан %	22
	гадаад улсын		23

1	Үйл ажиллагаа явуулж эхэлсэн огноо			X	<input type="text"/>
2	ААНБ-ын үйл ажиллагааны байдал	Жилийн турш ажилласан	1	X	<input type="text"/>
		Жилийн зарим сард нь ажилласан	2	Ажилласан сарын тоо	<input type="text"/>
	Улирлын ажиллагаатай	Улирлын ажиллагаатай	3	Ажилласан сарын тоо	<input type="text"/>
		Дампуурсан	4	Дампуурсан огноо	<input type="text"/>
	Өөр компанитай нэгдсэн	Өөр компанитай нэгдсэн	5	Нэгдсэн огноо	<input type="text"/>
		Өөр газар шилжсэн	6	Шилжсэн огноо	<input type="text"/>
	Огт үйл ажиллагаа явуулаагүй	7	Үйл ажиллагаагаа зогсоосон огноо	<input type="text"/>	
	Үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн	8	Чиглэл өөрчлөгдсөн огноо	<input type="text"/>	
	Бусад	9		<input type="text"/>	

1	Оршиж байгаа газрын хаяг		
2	Харилцах хаяг		
3	Утасны дугаар	4. Гар утас	5. Факсын дугаар
6	Цахим шуудангийн хаяг		
7	Компьютерийн тоо		

8	Байгууллага НӨАТ төлдөг эсэх?	Тийм - 1	Үгүй - 2
---	-------------------------------	----------	----------

Хэсэг 2. Ажиллагчид

		Нийт ажиллагчдын тоо		үүнээс: эмэгтэй
		А	[1]	
Бүтэн цагаар	Ажиллагчид (гэрээгээр ажиллагчдыг оруулаад)	1		
	Байгууллагаасаа тогтмол цалин авдаггүй гэрийн ажиллагчид болон хөлс авдаггүй гэрийн ажиллагчид	2		
	Бүгд (3 = 1 + 2)	3		
Бүтэн бус цагаар	Ажиллагчид (гэрээгээр ажиллагчдыг оруулаад)	4		
	Байгууллагаасаа тогтмол цалин авдаггүй ажиллагчид болон хөлс авдаггүй гэрийн ажиллагчид	5		
	Бүгд (6 = 4 + 5)	6		
Бүгд (7 = 3 + 6)		7		

Ажиллагчдын тоог жилийн дунджаар нөхнө.

Хэсэг 3. Нийт үйлдвэрлэлт

Хэсэг 3.1 Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

Үнийн дүн, мян.төг

	Гол нэр төрөл	Бүтээгдэхүүний код	Хэмжих нэгж	Эхний үлдэгдэл		Тайлант оны үйлдвэрлэлт		Гадагш борлуулаагүй бүтээгдэхүүний үйлдвэрлэлт*		Нийт үйлдвэрлэлт		Борлуулалт		Эцсийн үлдэгдэл	
				тоо	үнийн дүн	тоо	үнийн дүн	тоо	үнийн дүн	тоо	үнийн дүн	тоо	үнийн дүн	тоо	үнийн дүн
	[A]	[Б]	[В]	[1]	[2]	[3]	[4]	[5]	[6]	[7]	[8]	[9]	[10]	[11]	[12]
1	Цахилгаан	171000	мян.квт.цаг												
2	Галх	234300	т												
3															
4															
5															
6															
7															
8															
9															
10															
11															
12															
13	Бусад		X	X		X		X		X		X		X	
14	Дуусаагүй үйлдвэрлэл	888885	X	X		X		X	X	X		X	X	X	
15	Бүгд 15=1ч14	999999	X	X		X		X		X		X		X	

Багана [3] = [9] + [11] - [1] Багана [4] = [10] + [12] - [2] Багана [7] = [3] + [5] Багана [8] = [4] + [6]
 * энд харьяа газрууддаа шилжүүлсэн өөрийн бүтээгдэхүүн, ажиллагчдаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, мөн үйлдвэрийн эздийн хэрэглээндээ зориулан хэрэглэсэн бүтээгдэхүүн орно.

Хэсэг 3.2 Үйлдвэрлэлийн бус нийт орлого

мян.төг

	Үзүүлэлт	Дүн
1	Барилга, байшин түрээслүүлсний орлого	
2	Машин, тоног төхөөрөмж түрээслүүлсний орлого	
3	Үндсэн бус үйл ажиллагаанаас орсон орлого	
4	Гаднын байгууллагаас төлсөн цалин, хөлсний орлого	
5	Гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит орлого	
6	Үндсэн хөрөнгө худалдсаны орлого	
7	Хүүгийн орлого	
8	Ногдол ашгийн орлого	
9	Даатгалын байгууллагаас авсан нөхөн төлбөр	
10	Торгуулийн орлого	
11	Хандив, тусламжийн орлого	
12	Бусад	
13	Дүн (13=1 ч 12)	

Хэсэг 3.3 Худалдаж авсан барааг дахин борлуулснаас орсон орлого

мян.төг

	Үзүүлэлт	Дүн
1	Худалдаж авсан барааг дахин борлуулсны орлого	
2	Дахин борлуулахаар худалдан авсан барааны өртөг	
3	Дахин борлуулахаар худалдан авсан барааны эхний үлдэгдэл	
4	Дахин борлуулахаар худалдан авсан барааны эцсийн үлдэгдэл	
5	Худалдааны нэмэгдэл (5=1-2-3+4)	

Хэсэг 4. Үйлдвэрлэлийн зардал

Хэсэг 4.1 Үйлдвэрлэлд зарцуулсан түүхий эд, материал

	Түүхий эд	Түүхий эдийн код	Хэм-жих нэгж	Зарцуулсан түүхий эд	
				Биет хэмжээ	Үнийн дүн мян.төг
	[А]	[Б]	[В]	[1]	[2]
1	Гурил	231100	т		
2				
3				
4					
5					
6					
7					
8					
9					
10					
11	Бусад	888813	Х	Х	
12	Сэлбэг хэрэгсэл	777777	Х	Х	
13	Дүн (13 = 1 ч 12)	999990	Х	Х	
14	Нийт үйлдвэрлэлтэд ногдох түүхий эд, материал	999999	Х	Х	

Хэсэг 4.2 Эрчим хүч болон усны хэрэглээ

	Зардал	Зардал (Түүхий эд)-ын код	Хэм-жих нэгж	Зарцуулсан	
				Биет хэмжээ	Үнийн дүн мян.төг
	[А]	[Б]	[В]	[1]	[2]
1	Цахилгаан эрчим хүч	171000	квт. цаг		
2	Шатахуун, дизель түлш	333700	л		
3	Шатах, тослох материал	333800	л		
4	Түлшний мод	31300	м³		
5	Нүүрс	110300	т		
6	Хий	333600	м³		
7	Дулааны эрчим хүч (уур,халуун ус)	173002	м³		
8	Ус (үйлдвэрийн болон ундны)	692100	м³		
9	Бусад (үртэс, ...)				
10	Эрчим хүч, усны нийт хэрэглээ (10=1 ч 9)		Х	Х	

Хэсэг 4.3 Үйлдвэрлэлийн бусад зардал

	Үйлдвэрлэлийн бус зардал	мян.төг Дүн
1	Барилга, байшин түрээсэлсний зардал	
2	Машин, тоног төхөөрөмж түрээсэлсний зардал	
3	Тээврийн зардал	
4	Албан томилолтын унааны зардал	
5	Албан томилолтын байр, хоолны зардал	
6	Ажиллагчдын сургалт, давтан сургалтын зардал	
7	Шуудан, холбооны зардал	
8	Интернэтийн зардал	
9	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний төлбөр	
10	Санхүүгийн түрээсийн төлбөрийн хүү	
11	Гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит алдагдал	
12	Мэргэжлийн (гадны) байгууллагаар үйлчлүүлсний төлбөр (Хуулийн,геологийн, г.м.)	
13	Хөдөлмөр хамгааллын зардал	
14	Зар, сурталчилгааны зардал	
15	Урсгал засварын зардал	
16	Бичиг хэргийн зардал	
17	Ном, хэвлэлийн зардал	
18	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэл	
19	Ажиллагчдад мөнгөн ба биет хэлбэрээр өгсөн тусламж	
20	Зээлийн хүүгийн зардал	
21	Даатгалын зардал	
22	Бусдад өгсөн гишүүнчлэлийн татвар, хандив	
23	Торгуулийн зардал	
24	Ногдол ашгийн зардал	
25	Бусдын буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирол	
26	Гамшгийн улмаас учирсан хохирол	
27	Байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбогдсон зардал	
28	Бусад үйлчилгээ (дахин борлуулахаар худалдаж авсан барааны өртөг орохгүй)	
29	Бүгд (29 = 1 ч 28)	

Хэсэг 5. Ажиллагчдын цалин*мян.төг*

	Үзүүлэлт	Дүн
1	Бүтэн цагаар ажиллагчид (гэрээгээр ажиллагчдыг оруулаад)	
2	Бүтэн бус цагаар ажиллагчид	
3	Бүх ажиллагчид ($3 = 1 + 2$)	
4	Нийгмийн болон ЭМД-ын шимтгэл	
5	Бүгд ($5 = 3 + 4$)	

Хэсэг 6. Татвар, татаас*мян.төг*

	Үзүүлэлт	Дүн
1	Өөрийн эзэмшлийн авто тээвэр болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн албан татвар	
2	Онцгой татвар	
3	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	
4	Гаалийн албан татвар	
5	Газрын төлбөр	
6	Байгалийн нөөц ашигласны төлбөр	
7	Бусад татвар, хураамж	
8	Татвар, төлбөрийн дүн ($8 = 1 + 7$)	
9	Бүтээгдэхүүний татаас	
10	Цэвэр татварын дүн ($10 = 8 - 9$)	

Хэсэг 7. Тооцооны хүснэгт

	Үзүүлэлт	Дүн
1	Нийт үйлдвэрлэлт : $Хэсэг 3.1 + хэсэг 3.2 + хэсэг 3.3$	
2	Үйлдвэрлэлийн зардал: $Хэсэг 4.1 + хэсэг 4.2 + хэсэг 4.3$	
3	Ажиллагчдын цалин, НДШ : $Хэсэг 5, мөр 5$	
4	Татвар, төлбөр : $Хэсэг 6, мөр 10$	
5	Тооцооны (үйлдвэрлэлийн) ашиг : ($5 = 1 - 2 - 3 - 4$)	
6	Татвар төлөхөөс өмнөх цэвэр ашиг (балансаас нөхнө үү)	

Хэсэг 8. НИЙТ ХӨРӨНГӨ

мян.төг

Үзүүлэлт	МД	оны эхний үлдэгдэл	Нэмэгдсэн бүгд													Хасагдсан бүгд	Худалдсан					оны эцсийн үлдэгдэл
			Дотоод эх үүсвэр	Төсвийн хөрөнгө	Банкны зээл	Өөрийн хөрөнгө	Өөрөө үйлдвэрлэсэн	Бусад	Гадаад эх үүсвэр	Шууд хөрөнгө оруулалт	Зээл	Тусламж	Төсөл, хандив	Бусад	Худалдсан		Бараа солилцоогоор арилжсан	Үнэ төлбөргүй шилжүүлсэн	Акталж устгасан	Бусад		
A	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21
Үндсэн хөрөнгө мөр 1 = мөр (2 +17+23)	1																					
Биет хөрөнгө мөр 2 = мөр (3+4+8+9+13+14)	2																					
Орон сууцны барилга	3																					
Бусад барилга, байгууламж мөр 4 = мөр (5+6)	4																					
орон сууцны бус барилга	5																					
бусад байгууламж	6																					
үүнээс: авто зам	7																					
Их засвар, өргөтгөл, шинэчлэлт, сэргээн босголтын ажил	8																					
Машин, тоног төхөөрөмж мөр 9 = мөр (10+12)	9																					
тээврийн хэрэгсэл	10																					
компьютер, түүнийг дагалдах хэрэгсэл	11																					
бусад машин, тоног төхөөрөмж	12																					
Тавилга, ад хогшил	13																					
Өсөж үрждэг хөрөнгө мөр14 = мөр (15+16)	14																					
Ажлын болон ашиг шимийн мал, амьтан	15																					
Олон наст ургамал	16																					
Биет бус хөрөнгө мөр 17 = мөр (18+22)	17																					
Геологи, хайгуул, зураг төслийн ажил	18																					
Компьютерийн программ хангамж	19																					
Утга зохиол, урлагийн эх бүтээл	20																					
Лиценз, патент, эрхийн бичиг	21																					
Бусад биет бус үндсэн хөрөнгө	22																					
Газар	23																					
Материаллаг эргэлтийн хөрөнгө мөр 24=мөр (25+26+27+30+31)	24																					
Түүхий эд, материал	25																					
Сэлбэг хэрэгсэл	26																					
Дуусаагүй үйлдвэрлэл мөр 27 = мөр (28+29)	27																					
өсөж үрждэг бүтээгдэхүүнээс тооцсон дуусаагүй үйлдвэрлэл	28																					
бусад дуусаагүй үйлдвэрлэл	29																					
Бэлэн бүтээгдэхүүн	30																					
Дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүн	31																					
Үнэт зүйлс мөр 32 = мөр (33+35)	32																					
Үнэт металл, чулуу	33																					
Эртний эдлэл, бүтээл	34																					
Бусад үнэт зүйлс	35																					
НИЙТ ХӨРӨНГӨ мөр 36 = мөр (1+24+32)	36																					

Тэмдэглэгээний тайлбар: (ч) харгалзах үзүүлэлтүүдийн хоорондох тоонуудын нийлбэр
 Жишээ нь: мөр (6 ч 8) = мөр (6+7+8)
 (<=) харгалзах үзүүлэлтээс бага буюу тэнцүү

Тамга
тэмдэг

Захирал (Эзэн).....
 Ерөнхий (ахлах)нягтлан бодогч.....
 Эдийн засагч.....

Үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны

жилийн мэдээний маягт АҮ-7-г нөхөх заавар

Энэ тайланг үйлдвэрлэл эрхэлдэг санхүүгийн тайлан тэнцэл гаргадаг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага “Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу тогтоосон хугацаанд нь үнэн зөв, бүрэн нөхөж ирүүлнэ.

Хэсэг 1. Хаягийн хэсэг

ААНБ-ын хаягийн хэсэг нь ҮСХ-ны ААНБ-ын регистрийн санд өөрчлөлт, баяжуулалт хийхэд чухал ач холбогдолтой мэдээлэл юм. Аж ахуйн нэгж, байгууллагын хуулийн албан ёсны нэрийг бичиж, регистрийн дугаарыг тавина. Эхний хэсэг нь тухайн байгууллагын оршин байгаа хаяг юм. Харилцах хаяг гэдэг нь мэдээллийг тухайн газраас авах хаяг болно.

Аймаг, нийслэл, сум, дүүрэг, үйл ажиллагааны салбарын чиглэлийн нэрийг бичиж, зохих кодыг тавина.

Аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн хэлбэрийг дотор нь төрийн өмчийн-11; төрийн өмчийн оролцоотой-12; төрийн хамтарсан-13; орон нутгийн өмчийн-31; орон нутгийн өмчийн оролцоотой-32; орон нутгийн хамтарсан-33; монгол улсын иргэний-21; гадаадтай хамтарсан-22; гадаад улсын-23 гэж ангилан зохих кодыг тавина. 12, 13, 32, 33 гэсэн кодоор нөхсөн бол тухайн ААНБ-д төрийн болон орон нутгийн өмчийн эзлэх хувь, 22 гэсэн кодоор нөхөгдсөн бол гадны улсын эзлэх хувийг нөхнө.

Хэсэг 2. Ажиллагчид

Ажиллагч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ. Олон улсын нэгдсэн ангиллын дагуу ажиллагчдыг бүтэн, бүтэн бус цагаар ажилладаг ажиллагчид гэж ангилна. Бүтэн цагаар ажиллагчид гэдэгт хөдөлмөрийн хуулиар тогтоосон цагийн дагуу ажилладаг ажиллагчид, бүтэн бус цагаар ажиллагчдад хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллаж, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулиар зохицуулагддаг боловч долоо хоногийн ажлын цаг, ердийн ажлын үргэлжлэлээс бага хугацаагаар ажиллаж, цалин хөлс, орлого олдог, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч болон өөрөө хариуцан төлдөг ажиллагчдыг оруулна. Түүнчлэн энэ хоёр ангилал нь дотроо цалин хөлстэй ажиллагчид, цалин хөлс авдаггүй ажиллагчид гэж хуваагдана. Цалин хөлстэй ажиллагчдад хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан эсхүл аман гэрээ болон хоёр талын тохиролцоогоор ажилладаг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай хууль, Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг, ажил олгогчдод ажил, үйлчилгээ үзүүлснийхээ төлөө мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс авдаг ажиллагчид орно.

Ажиллагчдын тоог жилийн дунджаар гаргана. Жилийн дунджийг тооцоходоо сар бүрийн эцэст байгаа ажиллагчдын тооны нийлбэрийг нийт сарын тоонд харьцуулж гаргана.

Хэсэг 3.1 Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

Нийт үйлдвэрлэлтэд бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, үйлдвэрлэлийн бус нийт орлого, худалдааны нэмэгдэл буюу худалдаж авсан барааг дахин борлуулснаас орсон цэвэр орлогын дүнг оруулж тооцно.

Борлуулалт нь тухайн жилд гадагш борлуулсан бараа, бүтээгдэхүүний хэмжээ юм. Нийт үйлдвэрлэлт нь тухайн жилд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ. Нийт үйлдвэрлэлт нь үйлдвэрлэлт (эхний үлдэгдэл + тухайн жилийн борлуулалт - эцсийн үлдэгдэл) нэмэх нь гадагш борлуулаагүй бүтээгдэхүүний үйлдвэрлэлт (харьяа газрууддаа шилжүүлсэн өөрийн бүтээгдэхүүн, ажиллагчиддаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн мөн үйлдвэрийн эздийн хэрэглээндээ зориулан хэрэглэсэн бүтээгдэхүүн). Борлуулалт болон нийт үйлдвэрлэлтийн биет хэмжээ нь дуусаагүй үйлдвэрлэл болон бэлэн бүтээгдэхүүний үлдэгдлийн өөрчлөлтөөр мөн гадагш борлуулаагүй бүтээгдэхүүний өөрчлөлт зэргээр зөрнө. Борлуулалтын үнийн дүнг онцгой татвар ороогүй үнээр нөхнө. Үйлдвэрлэлт нь өмнөх оны үлдэгдэл дээр тухайн жилийн борлуулалтыг нэмж эцсийн үлдэгдлийг хасч балансална. Үйлдвэрлэлт нь тухайн жилд үйлдвэрлэсэн бүх нэр төрлийн бүтээгдэхүүнээр гарна.

Хэсэг 3.2 Үйлдвэрлэлийн бус нийт орлого

Энэ хэсэгт барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээсэлснээс орсон орлого болон үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, үндсэн хөрөнгө худалдсаны орлого, ногдол ашиг, хүү, торгуулийн орлого зэргийг оруулна.

Хэсэг 3.3 Худалдаж авсан барааг дахин борлуулснаас орсон орлого

Үйлдвэрлэл эрхэлдэг ААНБ-ын хувьд барааг дахин борлуулахаар худалдаж аваад борлуулсан тохиолдолд худалдааны нэмэгдэл тооцогдоно.

Худалдааны нэмэгдэл нь худалдаж авсан барааг борлуулсны орлогоос худалдан авсан барааны өртөг болон тухайн барааны жилийн эхний үлдэгдлийг хасч, жилийн эцсийн үлдэгдлийг нэмсэнтэй тэнцүү байна.

Хэсэг 4.1 Үйлдвэрлэлд зарцуулсан түүхий эд, материал

Завсрын хэрэглээнд тухайн тайлант хугацаанд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад орц байдлаар зарцуулсан бараа, үйлчилгээний материалын зардал болон үйлчилгээний төлбөрийг хамруулж тооцно. Борлуулагдаагүй бэлэн бүтээгдэхүүн, дуусаагүй үйлдвэрлэлд ногдох зардлыг завсрын хэрэглээнд оруулж тооцно.

Энэ хэсэгт бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан түүхий эд, сэлбэг хэрэгсэл, бусад материал хамрагдана (эрчим хүч болон усны хэрэглээ орохгүй). Нэр заагдсан түүхий эдээс гадна өөр төрлийн түүхий эд зарцуулсан бол нэмж оруулж өгнө.

Хэсэг 4.2 Эрчим хүч болон усны хэрэглээ

Энд тухайн байгууллагын зарцуулсан цахилгаан, дулааны эрчим хүч, түлш, шатах, тослох материал, усны хэрэглээ орно.

Хэсэг 4.3 Үйлдвэрлэлийн бусад зардал

Үйлдвэрлэлийн бусад зардал болон үйлчилгээний зардлууд энд хамаарна. Үндсэн бус үйл ажиллагааны зардалд хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны болон туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний зардал орно. Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний төлбөрт зээлийн хүүгийн зардлыг оруулахгүй. Байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбогдон гарсан зардалд уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын техникийн (нийтийн хэрэгцээнд тодорхой зориулалтаар ашиглахад бэлтгэх нөхөн сэргээлтийн анхан шатны ажиллагаа) болон биологийн (техникийн нөхөн сэргээлт хийсэн газарт хөрсний үржил шимийг сэргээх, ургамалжуулах зорилготой хийгдэх ажил) нөхөн сэргээлтийн зардал орно.

Интернэтийн зардалд тухайн байгууллага хэрэв өөрийн вэб хуудастай бол түүний үйлчилгээний төлбөр буюу хостингийн зардлыг мөн оруулна.

Хэсэг 6. Татвар, татаас

Газар, байгалийн нөөц ашигласны төлбөрт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр, улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, газрын төлбөр, ойгоос түлээ, мод бэлтгэж ашигласны төлбөр, агнуурын нөөц ашигласны төлбөр, ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашигласны төлбөр, байгалийн ургамал ашигласны төлбөр, рашаан, ус ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр зэргийг оруулна.

Бусад татварт зарим бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийн албан татвар, бууны албан татвар, автобензин, дизелийн түлшний албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, бусад татвар, хураамж зэргийг оруулна.

Хэсэг 8. Нийт хөрөнгө

Үндсэн хөрөнгө нь хөрөнгийн хуримтлалын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэг жилээс дээш хугацаанд давтан эсвэл үргэлжлэн ашиглагддаг биет ба биет бус хөрөнгөөс бүрдэнэ.

Багана (1) : Нийт хөрөнгө, оны эхний үлдэгдэл

Багана (21) : Нийт хөрөнгө, оны эцсийн үлдэгдэл

Багана (2) = багана (3 + 9)

Багана (3) = багана (4 + 5 + 6 + 8)

Багана (9) = багана (10 + 11 + 12 + 13 + 14)

Багана (15) = багана (16 + 17 + 18 + 19 + 20)

Багана (21) = багана (1 + 2 - 15)

Биет үндсэн хөрөнгө нь орон сууцны барилга, бусад барилга, байгууламж, машин, тоног төхөөрөмж болон өсөж үрждэг хөрөнгөөс бүрдэнэ.

Орон сууцны барилгад (мөр 3) хүн суурин амьдардаг сууцны зориулалттай барилга, оршин суугчдад зориулж суурилуулсан байгууламж, гарааж, мөн эзэмшигчдэд нь шилжүүлэх зорилготой баригдаж байгаа дуусаагүй орон сууцны барилга болон завь, ачааны усан онгоцон дээрх орон байр, нүүдлийн орон гэр зэргийг хамруулна.

Бусад барилга, байгууламж (мөр 4) нь орон сууцны бус барилга болон бусад байгууламжаас бүрдэнэ.

- **Орон сууцны бус барилга** (мөр 5) үйлдвэрлэл, худалдаа, нийтийн үзвэр, үйлчилгээний барилга, зочид буудал, зоогийн газар, боловсрол, эрүүл мэндийн байгууллагын барилга гэх мэт барилгууд орно.

- **Бусад байгууламж** (мөр 6) суваг шуудуу, сүлжээ, авто зам, гудамж, төмөр зам, онгоцны нислэгийн зам, гүүр, өргөгдсөн зам, туннель, газар доорх зам, усан зам, усан зогсоол, далан, хол зайд тавигдсан хоолой, холбооны болон эрчим хүчний шугам, кабель болон бусад шугам, олборлох, боловсруулах үйлдвэрийн байгууламж; спорт, амралтын байгууламж орно.

Их засвар, сэргээн босголт, өргөтгөлийн ажил (мөр 8) үндсэн хөрөнгө, компьютерийн программ хангамж болон газрын үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, ашиглагдах хугацааг уртасгах, тухайн хөрөнгөөр үйлдвэрлэх бүтээгдэхүүний чанар, хөрөнгийн бүтээмжийг сайжруулах зорилгоор хийгдсэн ажлыг хамруулна.

Үндсэн хөрөнгийг сайжруулахтай холбогдож хийгдсэн үндсэн гол ажлын зардлууд нь үндсэн хөрөнгийн хуримтлалын “Эдийн засагт шинээр бий болсон үндсэн хөрөнгийг олж эзэмших” гэсэн ангилалд багтана. Энэхүү шинэчлэгдсэн үндсэн хөрөнгө нь энэ үеэс эхлэн ҮТС-д энэ өртгөөрөө тусгагдаж, үндсэн хөрөнгийн элэгдлийг энэ дүнгээс тооцно.

Машин, тоног төхөөрөмж (мөр 9) тээврийн хэрэгсэл болон бусад машин, тоног төхөөрөмжийг оруулна. Хэрэв цэргийн зорилгоор эзэмшиж буй машин, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлд ашиглаж байвал мөн оруулна.

- **Тээврийн хэрэгсэл** (мөр 10) гэж хүн болон амьтан, бусад эд, зүйлсийг зөөх хэрэгслийг ойлгоно. Үүнд хүнд, хөнгөн даацын автомашин, усан онгоц, галт тэрэг, нисдэг тэрэг, сансрын хөлөг, мотоцикл, унадаг дугуй гэх мэт орно.
- **Бусад машин, тоног төхөөрөмж** (мөр 12) тээврийн хэрэгсэлд хамаарахгүй машин, тоног төхөөрөмж орно. Тухайлбал, ерөнхий зориулалтын машин; тусгай зориулалтын машин; албан хэрэгцээний бодох, тооцоолох төхөөрөмж; цахилгаан машин, аппарат хэрэгсэл; радио, телевиз болон холбооны тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл; эмнэлгийн тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл, нарийн хэмжилтийн аппарат хэрэгсэл, цаг, бугуйн цаг, цөмийн тогооны шингэн элемент (сум), хөгжмийн зэмсэг, албан газрын тавилга, уурын халаалтын генератор зэрэг орно.

Өсөж үрждэг хөрөнгө (мөр 14) байгууллагын шууд хяналт, хариуцлага, удирдлагын дор бүтээгдэхүүнийг давтан үйлдвэрлэх зорилгоор өсгөж, үржүүлж буй үржлийн, сүүний, махны чиглэлийн мал, амьтан (загас, гахай, шувуу, зөгий), ажлын мал; тарьж ургуулж байгаа чацаргана, алим, жимсний мод, бусад модыг оруулна. Тухайн жилд бойжуулсан төл орохгүй.

Энд жилээс жилд бүтээгдэхүүнээ өгдөг тарьж ургуулж буй мод, тухайлбал, жимсний бут, самрын мод, шүүс, резин, холтос, навчаар нь бүтээгдэхүүн хийдэг мод, бут орно.

Биет бус үндсэн хөрөнгөд нэг жилээс дээш хугацаагаар ашиглахаар төлөвлөсөн ашигт малтмалын хайгуулын зардал, компьютерийн програм хангамж, соёл урлаг, утга зохиол, урлаг, уран сайхны эх бүтээл зэрэг биет бус бусад үндсэн хөрөнгийг оруулна.

- **Ашигт малтмалын хайгуулын зардал** (мөр 18) нь газрын тос, байгалийн хий болон бусад ашигт малтмалын хайгуулын ажлын өртөг юм. Энэ зардалд лиценз авахын өмнөх зардал, лицензийн болон орд эзэмших зардал, хайгуулын өрөмдлөг, цооног гаргах, агаарын зураглал хийх зэрэг хайгуулын ажлын зардал орно.
- **Компьютерийн програм хангамж** (мөр 19) системийн болон хэрэглээний програм хангамж, програмын тодорхойлолт, ашиглах заавар зэргийг оруулна. Энд худалдан авсан болон өөрсдийн хэрэглээнд боловсруулсан програм хангамж аль аль нь орно. Түүнчлэн нэг жилээс дээш хугацаанд ашиглахаар төлөвлөж худалдан авсан, өөрсдөө боловсруулсан, томоохон хэмжээний мэдээллийн баазыг өргөжүүлсэн зардлыг түүнийг зарж борлуулах эсэхээс хамаарахгүйгээр оруулна.
- **Утга зохиол, урлагийн эх бүтээл** (мөр 20) кино, дуу бичлэг, гар бичмэл, соронзон хальсанд буулгасан онцлог үйл явдал, спорт, утга зохиол, урлаг, уран сайхны бүтээл зэргийг бичсэн, хадгалсан хуурцаг зэрэг орно. Энд өөрийн бүтээсэн эх бүтээл мөн орно.
- **Патент** (мөр 21) гэж тухайн шийдэл нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болохыг тодорхойлж, зохиогч нь тодорхой хугацаанд түүнийг өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичгийг хэлнэ.
 - **Шинэ бүтээл** гэж байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах, шинэ бүтээлийн шийдлийг хэлнэ.
 - **Бүтээгдэхүүний загвар** гэж бүтээгдэхүүний гадаад хэлбэр, хийцэд хамаарах гоёл чимэглэл, өнгө, өнгөний хослол агуулсан, шинээр зохион бүтээсэн, өвөрмөц шийдлийг хэлнэ.
- **Лиценз** (мөр 21) гэж патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болон ашигтай загварыг бусад этгээдэд ашиглуулах болзолтойгоор өгч байгаа зөвшөөрлийг хэлнэ.

- **Ашигтай загварын гэрчилгээ** гэж ашигтай загварыг эрх бүхий этгээд өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичгийг хэлнэ.
- **Биет бус бусад үндсэн хөрөнгө** (мөр 22) үйлдвэрлэлийн хэрэглээ нь хязгаарлагдмал, зөвхөн тухайн нэгжид өмчлөх эрх нь хадгалагддаг, эсвэл өөр нэгжид лицензээр эзэмшүүлсэн, өмнө нь ангилагдаагүй биет бус бусад үндсэн хөрөнгө орно.

Газар (мөр 23) өмчлөх эрхийг нь баталгаажуулж, мөн шилжүүлж болдог газар, хөрсний давхарга, тэдгээрт хамаарах газрын гадаргуугийн гол ус орно. Харин газар дээр байрлах, эсвэл түүгээр дамжих барилга, байгууламж; газар доорх хөрөнгө; газар доорх биологийн нөөц, усны нөөцийг оруулахгүй. Газар нь барилга, байгууламжийн газар, тариалангийн газар, амралтын газар болон бусад газар, тэдгээрт хамаарах газрын гадаргуугийн гол, уснаас бүрдэнэ.

Материаллаг эргэлтийн хөрөнгө нь тайлант, эсвэл тайлант хугацаанаас өмнө үйлдвэрлэсэн, борлуулахад бэлэн байгаа, эсвэл үйлдвэрлэлийн болон өөр бусад үйл ажиллагаанд хэрэглэхээр төлөвлөж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээнээс бүрдэх үйлдвэрлэсэн хөрөнгө болно.

Материаллаг эргэлтийн хөрөнгө нь түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн болон дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Түүнчлэн Засгийн газрын эзэмшилд байгаа стратегийн материал, үр тариа зэрэг улсын нөөцөд байгаа эргэлтийн бүх хөрөнгө орно.

- **Түүхий эд, материал** (мөр 25) дахин борлуулахаар биш харин үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа завсрын орцоор хэрэглэхээр төлөвлөж буй бүтээгдэхүүн орно.
- **Дуусаагүй үйлдвэрлэл** (мөр 27) нь үйлдвэрлэгчээс цаашид боловсруулалт хийхгүйгээр бусдад шилжүүлдэггүй, эсвэл үйлдвэрлэлийн дараачийн үе шатанд үргэлжлүүлэн боловсруулах хэсэгчилсэн боловсруулалт хийгдсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ. Энд өөрийн хэрэглээний үйлдвэрлэл, эсвэл худалдах/худалдан авах гэрээний дагуу өмчлөх эрх нь эцсийн эзэмшигчдээ шилжсэн дуусаагүй үйлдвэрлэлийг оруулахгүй. Дуусаагүй үйлдвэрлэл нь дараах өсөж үрждэг хөрөнгө болон бусад дуусаагүй үйлдвэрлэлээс бүрдэнэ.

Өөрөө үйлдвэрлээд өөртөө хэрэглэх зорилгоор барьж байгаа дуусаагүй барилга, байгууламжийн дуусаагүй үйлдвэрлэл нь энд орохгүй, үндсэн хөрөнгөд орно.

- **Өсөж үрждэг хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэлд** махны чиглэлээр өсгөж буй мал, амьтан болон арилжааны зорилгоор үржүүлж буй шувуу, загас, мөн мод бэлтгэлийн зориулалтаар тарьж ургуулсан мод, ургамал багтана. Түүнчлэн тухайн жилд бойжуулсан төл орно.
- **Бусад хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэлд** өсөж үрждэг хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэлээс бусад үйлдвэрлэгчээс хэсэгчилэн боловсруулалт хийсэн, үйлдвэрлэсэн, угсарсан бүтээгдэхүүн, үйлчилгээ орно.
- **Бэлэн бүтээгдэхүүн** (мөр 30) тухайн үйлдвэрлэгчээс үйлдвэрлэсэн худалдах, ачуулахад бэлэн болсон бүтээгдэхүүн орно.
- **Дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүн** (мөр 31) үйлдвэрийн газраас, тухайлбал, бөөний болон жижиглэнгийн худалдаачдын эзэмшиж байгаа, цаашид боловсруулалт хийхгүйгээр (хэрэглэгчийн сонирхлыг татахуйц байдлаар чимэглэснээс өөрөөр өөрчлөөгүй) борлуулах зорилготой бүтээгдэхүүн орно.

Үнэт зүйлс гэж үйлдвэрлэсэн хөрөнгө боловч үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглагдаагүй, ердийн нөхцөлд удаан хугацаанд чанараа алддаггүй, үнэ нь өсөх, эсвэл үнэ нь ядаж буурахгүй гэсэн магадлалаар хадгалах зорилгоор эзэмшдэг хөрөнгийг хэлнэ. Үнэт зүйлсэд үнэт металл, чулуу, эртний зүйлс болон урлагийн бусад бүтээл орно.

- **Үнэт металл, чулуу** (мөр 33) нь үйлдвэрийн газраас өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа орц байдлаар хэрэглэдэггүй үнэт металл, чулуу болно.
- **Эртний зүйлс, урлагийн бусад бүтээл** (мөр 34) уран зураг, баримал зэрэг түүх, соёлын үнэт зүйлс, эртний эдлэлийн зүйлсэд тооцогддог бүтээл орно.
- **Бусад үнэт зүйлс** (мөр 35) нь ямар нэгэн ангилалд ороогүй, жишээ нь үнэт чулуу, металаар хийсэн, чимэглэсэн үнэ цэнэтэй цуглуулга, гоёлын зүйлс болно.

Нэмэгдсэн үндсэн хөрөнгийг дотоод болон гадаад эх үүсвэрээр бий болгосон гэж ангилж багана 3, 9-д тусгана.

Дотоод эх үүсвэрээр бий болгосон хөрөнгийг төсвийн хөрөнгө (багана 4), банкны зээл (багана 5), өөрийн хөрөнгө (багана 6), бусад (багана 8) гэж хувааж бүртгэнэ. Өөрийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн үйлдвэрлэгчийн үйлдвэрлэсэн хөрөнгөөс өөрийн хөрөнгөөр үйлдвэрлэсэн хөрөнгийг ялган тусад нь багана 7-д харуулна.

Гадаад эх үүсвэрээр бүрдүүлсэн үндсэн хөрөнгийг шууд хөрөнгө оруулалт (багана 10), зээл (багана 11), тусламж (багана 12), төсөл хандив (багана 13), бусад гадаад эх үүсвэр (багана 14)-ээр бий болгосон гэж ангилна.

Хасагдсан хөрөнгийг худалдсан (багана 16), бараа, солилцоогоор арилжсан (багана 17), үнэ төлбөргүй шилжүүлсэн (багана 18), акталж устгасан (багана 19), бусад хасагдсан хөрөнгө (багана 20) гэж ангилж бүртгэнэ.

Бараа, солилцоогоор бусад байгууллага иргэдтэй арилжсан хөрөнгийг хасагдсан хөрөнгөд оруулах бөгөөд багана 17-д бүртгэнэ.

Үндэсний статистикийн хороо
Утас: 261560, 261559
Цахим хаяг: mesd@nso.mn